



**ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЯВУУЛДАГ “ГАЛ СЭНТИЙ” ХХК-ИЙН ОВООЛГЫН ШҮҮРЛИЙН ХУЧИЛЛЭГ
УСЫГ СААРМАГЖУУЛАХ БАГА ОВРЫН ЗӨӨВРИЙН ҮЙЛДВЭРИЙН ТӨСӨЛ**

2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 4376102/

ХЯНАСАН:

Орхон аймгийн БОАЖГ-ын ахлах мэргэжилтэн /О.Цэрэнчимэд/

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

Гал сэнтий ХХК-ийн Ерөнхий инженер /Н.Өлзийсайхан/

Гал сэнтий ХХК-ийн БО-ны асуудал хариуцсан ажилтан /Б.Дэмчигжав/

2023 он

Батлав:

БОАЖЯ-ны Хүрээлэн Буй Орчны
Бодлого Зохицуулалтын Газрын Дарга

Б.Буяннэмэх

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“Гал Сэнтий” ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Н.Нэргүй



**ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЯВУУЛДАГ “ГАЛ СЭНТИЙ” ХХК-ИЙН ОВООЛГЫН ШҮҮРЛИЙН ХУЧИЛЛЭГ
УСЫГ СААРМАГЖУУЛАХ БАГА ОВРЫН ЗӨӨВРИЙН ҮЙЛДВЭРИЙН ТӨСӨЛ**

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

/Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 4376102/

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБЗГ-ын мэргэжилтэн

П.Шинэцэцэг

Боловсруулсан:

“Гал сэнтий” ХХК-ийн

ХАБЭА, БО-ны асуудал хариуцсан ажилтан

Б.Дэмчигжав

2023 он

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн агуулга

1. Тухайн оны уулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга
2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт
4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
9. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт
10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт
11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт
12. Дүгнэлт
13. Хавсралтууд

“ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА”

ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр: “Овоолгын шүүрлийн хүчиллэг урсцыг цэвэршүүлэх болон боловсруулах бага оврын зөөврийн үйлдвэр

Төсөл хэрэгжих хугацаа: 2022-2026 он

Төслийн зорилго: Төсөл хэрэгжүүлэгч “Гал Сэнтэй” ХХК нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хүдрийн овоолгоос шүүрэх хүчиллэг усыг боловсруулах болон саармагжуулах ажил үйлчилгээ үзүүлэх 5/042-19 тоот гэрээ байгуулсны дагуу зөөврийн үйлдвэрийг байгуулан ажиллаж байна. Төсөл хэрэгжүүлэгч нь хүчиллэг ногоон усны үзүүлэх хор нөлөөг үгүй болгох, осол аюулын эрсдэлийг арилгах, усыг цэвэршүүлж, хаягдал болон техникийн усны үзүүлэлтэд нийцүүлэх, цэвэршүүлсэн усаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үйлдвэрийн технологийн эргэлтийн усны хэрэгцээг хангах, ногоон байгууламж, ил уурхайн технологийн замын усалгаа зэрэгт үр ашигтайгаар дахин ашиглах, цэвэршүүлэх явцад зэсийг дайвар байдлаар ялган авч эдийн засгийн үр ашигтай ажиллахыг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.

Төслийн хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллана. Үүнд:

- Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл багатайгаар үйл ажиллагаа явуулах
- Эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх
- Шинэ техник, технологийг нэвтрүүлэн ажиллах

1. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсөл хэрэгжүүлэгч “Гал сэнтий” ХХК нь уул уурхайн, гидрометаллургийн салбарт инженерчлэлийн зөвлөгөө өгөх, боловсруулах үйлдвэр барих чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулж байна. Нийт 52-н ажилчидтай үйлдвэрийн талбай дээр нийт 4-н ээлжээр ажилчид ажил гүйцэтгэж байна.

Төслийн байршил: Орхон аймгийн Баян-Өндөр сум, Баянцагаан багийн нутаг дэвсгэрт “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хашаанд №8-р овоолгын хойд хэсэгт байрладаг. Эрдэнэт хотын төвөөс 5км, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас 7.2км 1.65 га талбайд байрлана.

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүрээлэн буй орчны агаарын чанарын нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв.

Хүснэгт 2.1 Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжилт	Тайлбар
1	Овоолгоос тоос тоосонцор салхиар зөөгдөх, тээвэрлэлттэй холбоотойгоор агаарын бохирдол нэмэгдэх төслийн тээвэрлэлтэд ашиглаж буй тээврийн хэрэгслүүдийн дотоод шаталтын хөдөлгүүрүүдээс үүдэлтэй бохирдуулагч бодис агаар мандалд дэгдэж болзошгүй	Үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгсэл болон тээвэр хийх явцад агаар мандалд дэгдсэн бохирдуулагчид зөвшөөрсөн норм хэмжээнээс хэтэрсэн тохиолдлуудад дүгнэлт хийж шалтгааныг тогтоох, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх	Үйлдвэрийн үйл Ажиллагаанд ашигладаг нийт тээврийн хэрэгслүүд	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	Тээврийн хэрэгслийн оношлогоонд орох явцад бүх тээврийн хэрэгслийн агаар мандалд дэгдсэн бохирдуулагчийн хэмжээг тодорхойлуулж, бүх тээврийн хэрэгсэл хэвийн норм хэтэрсэн агаарын бохирдол үүсгэхгүй байгаа нь нотлогдсон.
		Гадаад орчны тоосжилтыг дарах зорилгоор усалгааг тогтмол хийж байх	Үйлдвэрийн талбайн гадаа орчинд	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	Үйлдвэрийн талбайн сул хөрстэй тоосжилт үүсгэж байгаа газруудад зүлэг тарьж, тогтмол услаж, ургуулсан.
		Хог хаягдлыг төслийн талбайн орчимд цуглуулалгүйгээр төвлөрсөн хогийн цэгт хаях /Хог хаягдлын цэгийг засаж тохижуулах/	Үйлдвэрийн талбайн гадаад орчинд	Хэрэгжүүлэж байгаа 90%	Хог хаягдалыг зориулалтын хогийн цэгт тогтмол ачиж буулгадаг.
		Ахуйн хог хаягдал болон сэлбэг материалын хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын хогийн цэгт цуглуулах, хоёрдогч түхий эд болгож ашиглахаар ялгасан зүйлийг холбогдох цэг, үйлдвэрт тээвэрлэж хүргэх,борлуулах	Нийт ажилчид	Тогтмол хэрэгжиж байна	Хогийг ангилан ялгаж зориулалтын хогийн цэгт буулгадаг.
		Төсөл хэрэгжих хугацаанд мэргэжлийн байгууллагаар агаарын сорьц авхуулан шинжилгээхийлгэж, зөвлөгөө авч байх	Ажлын өрөө болон ахуйн байрууд	Тогтмол хэрэгжиж байна	Агаарын сорьцын шинжилгээг тогтмол хийлгэдэг.
Уурын зуухны яндангаас агаар блхирдуулагч тархах	Зуухны янданд циклон шүүлтүүр тавих	Үйлдвэрийн талбай	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	Уурын зуухны янданд циклон шүүлтүүр суурилуулж, яндангаас гарах торгогны хэмжээг багасгасан.	

2		Агаарт дэгдэж буй бохирдолд тогтмол хяналт тавьж ажиллах	Үйлдвэрийн талбай	Тогтмол хэрэгжиж байна	Уурын зуухны яндангаас ялгарч буй тортог, утаанд тогтмол хяналт тавьж, цэвэрлэгээ үйлчилгээг байнга хийдэг.
	Хандлах цехийн үйл ажиллагаанд ашиглаж буй бодисын халалтаас агаар бохирдуулагч тархах	Агаар бохирдуулагчид ихээр үүсэж буй цех, дамжлагуудад агааржуулалтын системийг тогтмол шалгах, үйл ажиллагааны хэвийн Байдлыг хангах, шүүлтүүрийг солих	Хандлах цех	Тогтмол хэрэгжиж байна	Агаар бохирдуулагч ихээр үүсэж буй цех хэсгүүдэд дефлектор, агааржуулах вентилятор суурилуулсан.
		Бодисуудад халалт үүсэхээс сэргийлж саармагжуулах арга хэмжээ авах	Хандлах цех	Тогтмол хэрэгжиж байна	Бодис, уусмалын халалтыг байнга хянаж, саармагжуулах арга хэмжээ авдаг.

2.2 Газрын гадарга, хөрс, ургамалын нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 2.2 Газрын гадарга, хөрс, ургамалын нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжилт	Тайлбар
1	- Тээврийн хэрэгслийн явалт, ажилчдын хөлөөр хөрс эвдрэх, ургамал гэмтэх, эвдрэл үүсэхээс гадна шатах тослох материал, хог хаягдал, бохирын шингэн алдагдсанаас хөрсөнд бохирдол үүсэж болзошгүй	Төслийн эвдэгдсэн талбайн бүртгэл хөтлөх, онц шаардлагатайгаас бусад талбайд ашиглалт явуулахгүй байх арга хэмжээ авах, тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Үйлдвэрийн талбай дээр	Тогтмол хэрэгжиж байна	Тээврийн хэрэгсэл, хүн зорчдоггүй газруудыг хашиж хамгаалан, ялгасан.
		Дахин ашиглагдахгүй болсон талбайд тэмдэг тэмдэглэгээ байршуулж байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх	Үйлдвэрийн талбай дээр	Тогтмол хэрэгжиж байна	
		Бетон тунгаагуур хийх	8-р овоолгын доор хүчиллэг урсцын суваг дээр	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	Хүчиллэг урсцыг байгалийн хөрсөнд шингэх, алдагдахаас сэргийлж 6000x4000x3000мм хэмжээтэй бетон тунгаагуурыг 2023 оны 6 сард барьж дуусгасан.
		Орчныг байнга чийглэж ургамал нөмрөгийг сэргээн сайжруулах зорилгоор бороожуулалтын (шүршүүр) систем бий болгох, ногоон байгууламжийг усалж арчлах	Үйлдвэрийн талбай	Тогтмол хэрэгжиж байна	Зам усалгаа, болон талбай усалгааг дулааны улиралд тогтмол хийдэг.
		БОХШХ-ын үр дүнг тодорхойлж биелэлтийн тайланд тусгах, тус үр дүнд үндэслэн стандартаас илүү бохирдолтой талбайн хөрсийг солих, саармагжуулж хаях арга хэмжээг тухайн жилийн байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлж байх	Үйлдвэрийн ажилчдын хэрэгцээнд	Тогтмол хэрэгжиж байна	Тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байгаа.

2	Хог хаягдал, үнсний хаягдлыг зориулалтын цэгт цуглуулаагүйгээс хөрсөн бүрхэвч бохирдох	Хог хаягдлыг зориулалтын засаж тохижуулсан цэгт ангилан хаях, цаг тухайд нь ачиж зайлуулах	Үйлдвэрийн талбай	Тогтмол хэрэгжиж байна	Хог хаягдлыг зориулалтын засаж тохижуулсан цэгт ангилан хаяж, цаг тухайд нь ачдаг.
	Химийн бодисын ашиглалт хадгалалтыг горимыг алдуулах, сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг алдагдуулснаас хөрсөнд нэвчих, шүүрэх асгарах	Химийн бодис асгарсан тохиолдолд хөрсийг солих, саармагжуулж хаях арга хэмжээг авах, хүрз элс зэрэг хэрэглэх материалуудыг бэлэн байлгах	Үйлдвэрийн талбай	Тогтмол хэрэгжиж байна	Химийн бодис асгарсан тохиолдолд хөрсийг солих, саармагжуулж хаях арга хэмжээг авдбг, хүрз элс зэрэг хэрэглэх материалуудыг бэлдсэн.

2.3 Усанд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 2.3 Усанд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжилт	Тайлбар	
1	Бохир ус агуулах, хадгалах байгууламжуудын ус үл нэвчүүлэх хамгаалалт хагарах, цоорох, бохир ус дамжуулах хоолойд гэмтэл үүсэх, шатах тослох материал асгаралт зэрэг нь бохирдлын эх үүсвэр болно. Түүнчлэн цөөрмүүдээс гарах хөвөх насосуудад гэмтэл үүсэх, цоорсноос хөрсөнд нэвчин гүний ус бохирдож болзошгүй.	Технологийн ус хэрэглээний бүртгэл хөтөлнө. Усны зарцуулалтыг тооцож байх, технологийн хэрэглээнд ашиглаж буй эх үүсвэр /худгууд/-ийн бичиг баримтын бүрдлийг хангаж ажиллах	Үйлдвэрийн талбай дээр	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	Бүртгэл, мэдээлэл, зарцуулалтыг тогтмол хөтөлж, баталгаажуулдаг.	
		Технологийн хэрэглээнд ашиглагдаж буй худгуудын орчимд мониторингийн цооног байгуулах, насос станц орчимд ашиглагдаж буй худгийн ундарга, нөөцөд нөлөөлөх нөлөөлөл байгаа эсэхийг тодорхойлох	Үйлдвэрийн талбайн болон Эрдэнэт үйлдвэрийн ТӨҮГ-н тогтоож өгсөн талбай	Тогтмол хэрэгжиж байна		
		Ахуйн бүх төрлийн бохир ус дамжуулах хоолойн холбоосуудаар ус алдагдаж байгаа эсэхийг үе үе хянах, боломжтой бол тоноглох, хянаж байх	Үйлдвэрийн талбай дээр	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	Бохир ус дамжуулах хоолойн холбоосуудаар ус алдагдаж байгааг тогтмол хянаж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийдэг.	
		Хөвөгч насосуудын бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг тогтмол хянаж ажиллах	Үйлдвэрийн талбай дээр	Тогтмол хэрэгжиж байна	Найдвартай ажиллагаа, аюулгүй ажиллагааг тогтмол хянаж ажилладаг.	
2	Химийн бодисын ашиглалт хадгалалтыг горимыг алдуулах, сав баглаа боодлынбүрэн бүтэн байдлыг алдагдуулснаас хөрсөнд нэвчих, шүүрэх асгарснаас гүний ус бохирдох	Химийн бодис асгарсан тохиолдолд хөрсийг солих, саармагжуулж хаях арга хэмжээг авах, хүрз элс зэрэг хэрэглэх материалуудыг бэлэн байлгах	Үйлдвэрийн талбай дээр	Тогтмол хэрэгжиж байна	Химийн бодис асгарсан тохиолдолд хөрсийг солих, саармагжуулж хаях арга хэмжээг авдаг, хүрз элс зэрэг хэрэглэх материалуудыг бэлдсэн.	

3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 3.1 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Хэрэгжилт	Тайлбар
1	Төслийн талбайн орчим нөлөөлөлд өртсөн талбайг нөхөн сэргээх	Талбайн хөрсийг бордох, хөрсний чанарыг сайжруулах	м ²	100	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	Ахуйн байр болон ОО, душны контейнерийн гадна 100м2 газар зүлэг тарьж ургуулсан.
		Ургалтад анхаарал, хяналт тавих, усалгаа, тордлогоо байнга хийх, арга хэмжээг авах, ногоон байгууламжийн орчимд хаалт, хамгаалалт тавих/ цэцэрлэг, зүлэг ногоо услах	га	1,65	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	Тогтмол хийж байна.

4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 4.1 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Хэрэгжилт	Тайлбар
1	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Бүх нийтээрээ тэрбум мод тарих өдрүүдээр 2022 онд тарьсан 1000ш модны гурван замын ногоон зурваст байрлах хашааг дахин янзалж засварлах	3-н замын постны наад талд Эрдэнэт самбарын хойно	500м	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	2023 оны 5 болон 10-р сард өөрсдийн нөөц бололцоогоор засаж, янзалсан.
		Бүх нийтээрээ тэрбум мод тарих өдрүүдээр 2023 онд 500-с дээш навчит болон шилмүүст мод тарих	Дулааны цахилгааны станцын урд талын Далиу булгийн хажууд	500ш	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	2023/05/12-нд 500ширхэг бургас тарьж, арчилгаа, усалгааг хийж байна.
		Бүх нийтээрээ тэрбум мод тарих өдрүүдээр 2023 онд 500-с дээш навчит болон шилмүүст моднуудыг тарьж ургуулж, арчилгаа, усалгаа хийх	3-н замын постны наад талд Эрдэнэт самбарын хойно	300ш	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	2023/10/13-нд 300 ширхэг улиас мод тарьж, арчилгаа, усалгааг хийж байна.
2	Байгаль орчинд тархсан хог хаягдлыг цэвэрлэх	Хавар болон намрын улиралд	Аймгийн эзэнгүй хээрийн хог хаягдлыг цэвэрлэх	2	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	2023 оны 4 болон 10-р сард Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-н ИУ-н №3-р постны ойр орчмыг цэвэрлэж, хогийг ачсан.

5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Гал сэнтий” ХХК-ний төслөөс оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх шаардлага үүсгэхгүй байгаа юм.

6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа явуулж буй тус газар нь үйлдвэрлэлийн районд байрладаг. Тухайн талбайд түүх соёлын дурсгалт зүйл илрээгүй бөгөөд төслийн хэрэгжилтийн үед ямар нэг зүйл илэрвэл мэргэжлийн байгууллагад мэдэгдэх, хамгаалах арга хэмжээ авна.

7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7.1 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэрэгжилт	Тайлбар
1	Химийн бодисын сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдах, орчинд тархах	Байнгын хяналт тавих	Химийн бодисын агуулах, цехүүд	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	Химич инженер, лаборант, агуулахын нярав, технологийн операторууд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.
		Нөөцөд сав баглаа боодол байлгах (үйлдвэрт хадгалагдаж буй сав баглаа, боодлыг ариутгаж ашиглахаас гадна нөөцөд шинэ сав, баглаа боодол авч хадгалах)	Лаборант, химийн бодисын агуулах, цехүүд	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	Нөөц шинэ сав, суулгыг Химич инженерийн тооцоолол, төлөвлөгөөний дагуу авч, нөөцөлсөн байгаа.
		Шаардлагатай үед алдагдсан химийн бодисыг цэвэрлэх, саармагжуулах арга хэмжээ авах багаж хэрэгсэлтэй болох	Саармагжуулах бүтээгдэхүүн, хэрэгслүүдийн нөөцтэй байх	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	Зориулалтын химийн бодис асгаралтын үед хэрэглэгдэх иж бүрэн багцыг “Цэцүүх трейд” ХХК-аас худалдан авсан байгаа.
		Химийн бодисын үлдэгдэл, сав баглаа боодлыг тусгай зөвшөөрөлтэй Цэцүүх трейд ХХК-р устгуулах	Гэрээнд тусгагдсаны дагуу	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	Химийн бодисын хаягдалын зориулалтын сав бэлдэж байршуулж, хаяг тэмдэг тэмдэглэгээг тавьж байршуулсан.
		Болзошгүй аюул ослын үед ашиглах мөнгөн хуримтлал бүрдүүлэх	Химийн бодисын алдагдлын аюулын тохиолдолд ажилчдыг тусгай хамгааллын хэрэгслээр хангах зориулалтын нөөц бүрдүүлэх /баг, бээлий, гутал, комбинкон гэх мэт/	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	Санхүүд төсөвлөгдсөн хуримтлалтай байгаа.

2	Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Цаг агаарын мэдээг байнга авч үйл ажиллагаатайгаа холбон ажиллах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх гарын авлагатай болох	Нийт ажилчид	Тогтмол хэрэгжиж байгаа	Цаг агаарын мэдээлэлд тулгуурлан ажилчдын ажлыг хуваарилах, ажилчдад хэрхэн хувцасаа тохируулах талаар мэдээлэл хүргэх гэх мэт санамж, анхааруулгууд цахимаар болон аман байдлаар ажилчдад хүргэж байна.
		Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг өгч байх, самбартай болох	Тухайн ажилтаны гүйцэтгэж бүх ажил үүрэг	Тогтмол хэрэгжиж байгаа	ИТА-н ажилчид дотооддоо сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалт, дадлага тогтмол ордог. Мөн мэргэжлийн зөвлөх эмчээр сургалт зохион байгуулан тогтмол мэдээлэл авч байгаа.
		Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл, холбооны хэрэгсэлтэй болох	Нийт ажилчид болон тэдний гэр бүл	Тогтмол хэрэгжиж байгаа	Гэнэтийн аюул ослын үед хэрэглэх нөөц тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бүрдүүлэлтийг ханган ажиллаж байна. Холбооны хэрэгслийг 2024 оны БОМТ-д тусгаж хэрэгжүүлэх.
		Технологийн доголдлын үед гарах ослоос урьдчилан сэргийлж, ослын үед авах арга хэмжээнүүдийг нөлөөллийн хэлбэр бүрээр төлөвлөн тусгах	Нийт ажилчид	Тогтмол хэрэгжиж байгаа	Технологийн доголдлын үед гарах ослоос урьдчилан сэргийлж, ослын үед авах арга хэмжээнүүдийг нийт ажилчдад ойлгуулж, таниулах, мэдлэг эзэмшүүлэх

8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 8.1 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт	Тайлбар
1	Ахуйн хог хаягдал	Хог хаягдлыг төслийн талбайн орчинд цуглуулалгүйгээр төвлөрсөн хогийн цэгт зайлуулах	Үйлдвэрийн талбайн гадна болон дотор хог хаягдал	Тогтмол хэрэгжиж байгаа	Үйлдвэрийн талбайн цэвэрлэгээ үйлчилгээг өдөр тутам тогтмол хийж, ангилан хаях зориулалтын хогийн савнууд дүүрсэн тухай бүр Хот тохижуулах газартай хийсэн гэрээний дагуу тогтмол хаяж, устгаж байгаа. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-н зааж өгсөн талбайг тогтмол хуваарийн дагуу цэвэрлэж, хогийн цэгт хаяж устгаж байна.
		Тогтмол хугацаанд тээвэрлэж хаяж байх	Хатуу хог Хаягдлыг устгах	Тогтмол хэрэгжиж байгаа	Хэрэглээнээсээ шалтгаалаад үйлдвэрийн гадна талбайд нийт ангилан ялгасан хаягтай 10н хог сав байдаг
		Уурын зуухнаас гарах үнс хаях		Тогтмол хэрэгжиж байгаа	Зуухны үнсийг 7 хоногт 1 удаа төвлөрсөн хогийн цэг рүү ачиж буулгадаг.
2	Үйлдвэрийн шингэн хог хаягдал	Хаягдал усны дахин ашиглалтын хувь хэмжээг нэмэгдүүлэх боломжийг судлах, дэвшилтэт технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх	Бохир ус зайлуулах гэрээнд тусгагдсанаар	Тогтмол хэрэгжиж байгаа	
3	Аюултай буюу химийн хог хаягдал	Химийн бодисын сав баглаа боодлыг сайтар шалгах, байгаль орчинд хаягдахаас сэргийлэх, тусгай зөвшөөрөлтэй байгууллагад нийлүүлэх	Цэцүүх Трэйд ХХК-тай хийсэн гэрээнд тусгагдсанаар	Тогтмол хэрэгжиж байгаа	

9. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Дээж авах цэг	Мониторинг хийх үзүүлэлтүүд	Хугацаа Ба Давтамжийн тоо	Нийт зардал,төг	Хэрэгжилт
1	Агаарын чанар	Хандлах цехэд /49° 1'19.26"N, 104° 5'49.06"E / Зуухны яндангийн дэргэд /49° 1'19.35"N, 104° 5'49.90"E / Төслийн талбай руу орох хаалганы дэргэд буюу Зэс эрдэнийн хувь ХК-ийн тээврийн замтай огтлолцож буй хэсэгт / 49° 1'24.19"N, 104° 5'48.48"E/	Тоосжилт (PM10, PSM, PM2.5) • Бохирдлын цэгэн эх үүсвэр (SO2, NO2, CO) • Гадаад болон дотоод орчны дуу чимээ, доргио, чичиргээ • Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг, чийгшил болон физик бохирдлын түвшин)	Жилд 2 удаа 3 цэгт /4 болон 9 сард/	650.000	Байгаль орчны судалгаа шинжилгээний төвөөр 2023 оны 8 сард ус, хөрсний шинжилгээг хийлгэсэн.
2	Усны чанар	Унд ахуйн ус	• Усны рН, цахилгаан дамжуулах чадвар нүүрстөрөгчийн исэл СО3, хүчил НСО3 - ,	Жилд 2 удаа 3 цэгт /4 болон 9-р сарууд/	300.000	

		Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Хяналтын цооног 3 /49° 02.49N, 104° 09.42E/	кальци Ca ²⁺ , хлор Cl ⁻ , кали K ⁺ , магни Mg ²⁺ , сод Na ⁺ , хүхэр S, хүнцэл As, бор B, бари Ba, кадми Cd, кобальт Co, хром Cr, зэс Cu, төмөр Fe, мөнгөн ус Hg, манган Mn, молибден Mo, никель Ni, хар тугалга Pb, селени Se, силикон Si, ванади V, цинк Zn, хөнгөн цагаан Al, мөнгө Ag			
		Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Хяналтын цооног X /49° 01.48N, 104° 05.65E/				
3	Хөрсний чанар	Саармагжуулсан усны цөөрөм / 49° 1'20.45"N, 104° 5'47.88"E /	Хөрсний үе давхаргын зузаан (см), элэгдэл эвдрэлийн нөхцөл • ялмагийн агууламж, нийт азот, карбонат, Ca, Mg, P ₂ O ₅ , K ₂ O • хөрсний рН, давсжилт, чийгшил • Pb, As, Cd, Hg, Cu, As, Zn, Se –ийн хүнд металлын агууламж	Жилд 1 удаа 3 цэгт /9-р сар/	500.000	
		Төслийн талбайн хог хаягдлын цэгийн орчимд /49° 1'23.37"N, 104° 5'50.07"E/				
		Химийн бодисын агуулах орчимд /49° 1'19.59"N, 104° 5'47.13"E/				
4	Ургамлан нөмрөг	Ногоон байгууламж орчимд /49° 1'20.85"N,104° 5'50.24"E/	Ургамлын зүйл • Бодгалийн тоо, бүрхэц • Дундаж өндөр • Биомасс	Жилд 1 удаа	350.000	
Нийт				1.800.000		

10. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хуваарь	Хэрэгжилт	Тайлбар
1	БОМТ-д тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан үйл ажиллагааг зохион байгуулах, дотоод журам тогтоож мөрдөх	Үйл ажиллагааны зардлаас		2023 он	Тогтмол хийгдэж байгаа	ХАБЭА, БО-н ажилтан хариуцан хийдэг.
2	Хог хаягдлын тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, хог хаягдлыг аль болох дахин ашиглах, дахин боловсруулах, тээвэрлэх /Ахуйн хог хаягдлыг тээвэрлэх, устгах гэрээ байгуулах/			2023 он	Тогтмол хийгдэж байгаа	Тогтмол угтгаж, ачилт хийдэг.
3	Химийн бодис худалдан авах, ашиглах тусгай зөвшөөрөл авах /3 жил тутамд эсвэл химийн бодисын хэрэглэх хэмжээ, жагсаалт, нэр төрөлд өөрчлөлт орох тутамд/ Гал сэнтий ХХК-ийн аюултай хог хаягдал үүсгэгчийн дугаар: 001229			3 жил тутам	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	Зөвшөөрөл авсан. Хугацаа дуусаагүй.
4	Химийн бодис худалдан авах, тээвэрлэх, устгах гэрээ байгуулах			Жил бүр	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	Гэрээг Цэцүүх ХХК-тай байгуулсан.
5	Галын аюулгүй байдлын дүгнэлт			Жил бүр	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	Орхон аймгийн ОБЕГ-аар галын дүгнэлт гаргуулсан.
6	Ажлын байрны дүгнэлт			Жил бүр	Хийгдээгүй	2024 оны эхний улиралд багтаан хийх
7	Химийн бодисын агуулахын дүгнэлт			Жил бүр	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	Дүгнэлттэй

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хуваарь	Хэрэгжилт	Тайлбар
1	Ажилтнуудыг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтад тогтмол хамруулах, чадавхжуулах	-		2024 он	Хэрэгжүүлээгүй	2024 онд бүрэн хэрэгжүүлнэ
2	Ажилтнуудыг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувцас хэрэгслээр тогтмол хангах			Жил бүр	Тогтмол хийгдэж байгаа	Ажилчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувцас хэрэглэлээр тогтмол хангадаг.
3	Шаардлагатай үед хэрэглэх иж бүрэн эмийн санг заавартай нь байрлуулах, тогтмол хугацаанд нөхөн сэлбэх	Үйл ажиллагааны зардлаас		2023 он	Тогтмол хийгдэж байгаа	Шаардлагатай эмийг байнга байршуулж, тодорхой хугацаанд нөхөн сэлбэдэг.
4	“COPPER FESTIVAL” эвент арга хэмжээнд дэмжлэг үзүүлэн, хамтран зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаас		2023 оны 9 сард	Бүрэн хэрэгжүүлсэн 100%	2023/09-22-23-ны өдрүүдэд Зэс фестивалд байгууллагаараа оролцсон.
5	Байгаль орчны аудит хийлгэх 2023 он	Үйл ажиллагааны зардлаас		2024 он	Хэрэгжүүлээгүй	2024 оны 1-р улиралд багтаан хийх.
	Нийт	Үйл ажиллагааны зардлаас				

**11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН
ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	6	7
1	Төсөл хэрэгжүүлэгч “Гал Сэнтий” ХХК, Орхон аймгийн БОАЖГазар, Баян цагаан багын иргэдийн нийтийн хурлаар танилцуулах	Тайлан тавих	Байгаль орчны менежментийн хүрээнд хийгдсэн ажил түүний биелэлтийн үр дүнг танилцуулах	2023 оны 11 сарын 02-нд	ХАБЭА, БО-ны ажилтан	Аймгийн БОАЖГазар
	Нийт					


12. ДҮГНЭЛТ:

Гал сэнтий ХХК нь 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дээрх ажлуудыг хийж гүйцэтгэхээр тусгасан.

1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ- 21 ажил
 2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ- 2 ажил
 3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ- 4 ажил
 4. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ- 9 ажил
 5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ- 5 ажил
 6. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР- 1 ажил
 7. УДИРДАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ-12 ажил
- **2023 оны БОМТ-д нийт 54 ажил төлөвлөсөн.**
 - **Гүйцэтгэл: Хийх шаардлагатай 54 ажлаас 51 ажил нь бүрэн хэрэгжүүлсэн, тогтмол хийгдэж байгаа ажлууд**



Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт



Хүчиллэг урсцыг байгалийн хөрсөнд шингэх, бохирдуулахаас сэргийлж хуванцар хоолой, геомембран хулдаас ашиглан суваг хийсэн.



Хүчиллэг урсцын хог шороог тунгаах, шүүх зорилгоор 6000x4000x3000мм хэмжээтэй 72м³ эзэлхүүнтэй бетон тунгаагуур барьж хүчиллэг урсцын хог болон механик хольцыг тунгаан 45,000 м³-н хяналтын цөөрөм рүү оруулж байна.
Бетон тунгаагуур барьсан төсөвт өртөг **47,000,000 ₮**



Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт



Орчны тоосжилт дарах зорилгоор ногоон байгууламж, зам талбайн усалгааг тогтмол хийж гүйцэтгэдэг.



Нөхөн сэргээлт, ногоон байгууламж байгуулах төлөвлөгөөний биелэлт



10x10 метр талбайд зүлэг тарьж ургуулсан. Үйлдвэрийн хашаан доторх ногоон байгууламжыг тогтмол усалж, ургалтыг сайжруулсан.

Зам талбайн усалгааг тогтмол хийж тоосжилтыг дардаг.



Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Гал сэнтий ХХК



2023 оны хаврын мод тарилтаар Далиу булгийн эхэнд 500 ширхэг бургас тарьсан.

2023 оны намрын мод тарилтаар 3-н замын постны хажуу талд Эрдэнэт самбарын хойно 300 ширхэг улиас тарьсан. 2022 оны намар тарьсан модны ургалт муугаас нөхөж тарьсан.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ -н хуваарьт талбайг улиралд 1 удаа цэвэрлэж, хог хаягдлыг ачдаг.



Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Гал сэнтий ХХК



Химийн бодис асгаралтанд хэрэглэх иж бүрдэл худалдан авсан.

Гал түймэр болон галын аюулгүй байдлын талаарх дадлага сургалтыг жилд 2 доошгүй удаа зохион байгуулдаг.



Хог хаягдалын менежментийн төлөвлгөөний биелэлт

Гал сэнтий ХХК



- 2023 оны 10 сарын 27-ны өдөр Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-н хуваарьт талбайн цэвэрлэгээг хийж гүйцэтгэсэн. Нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй 4м3 хог ачиж, зориулалтын цэгт буулгав. Тухайн талбайн цэвэрлэгээг улиралд 1 удаа хийдэг.

- Мөн үйлдвэрийн хог болон зуухны үнсийг тогтмол ачиж зориулалтын хогийн цэгт буулгадаг.



Гадаргын усны шинжилгээ



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
ЗЭРЭГЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

ХЯНАЛТЫН ТӨВ ЛАБОРАТОРИ

/Central inspection laboratory/
Хяналтын төв лаборатори, Улаанбаатар хот, Засаг захиргаа
Төв, 100000

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН
СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС
/Test result of accredited laboratory/



TL 092
MNS ISO 17025

Захиалагчийн нэр /Customer name/: "Гал Сэнтий" ХХК

Дээжний дугаар /Test number/	Дээжний хаяг, байршил /Sample location/	Уст цэгийн төрөл /Type of water/		
№ 1329	Далиу булаг	Гадаргын ус 49°01'51.9" 104°06'45.6"		
Дээжний тоо, хэмжээ /Quantity of the sample/	Дээж хүлээн авсан огноо /Date receipt/	Шинжилсэн огноо /Analyzing date/	Хэвлэсэн огноо /Printed date/	Техникийн шаардлага / Technical requirements/ MNS 4586.98
2.0л / 2.0L /	2023.08.14	2023.08.14- 08.20	2023.08.21	Шинжилгээний эргэн стандарт /Test method/ MNS ISO 11885:2011 /SP/

№	Үзүүлэлт /Parameter/	ЗДХ /Technical specification/ мг/л	Үр дүн /Test result/	№	Үзүүлэлт /Parameter/	ЗДХ /Technical specification/ мг/л	Үр дүн /Test result/
1	Манган (Mn) м/л /Manganese Mn, mg/L /	<0.1	<0.005	11	Хөвөгцөгөөв (Al) м/л /Aluminum Al, mg/L /	-	<0.0031
2	Никель (Ni) м/л /Nickel Ni, mg/L /	<0.01	<0.0017	12	Лити (Li) м/л /Lithium Li, mg/L /	-	<0.0031
3	Зэс (Cu) м/л /Copper Cu, mg/L /	<0.01	<0.0024	13	Барил (Ba) м/л /Barium Ba, mg/L /	<0.7	<0.0062
4	Кадмий (Cd) м/л /Cadmium Cd, mg/L /	<0.005	<0.0016	14	Мөнгө (Ag) м/л /Silver S, mg/L /	<0.1	<0.0031
5	Кобальт (Co) м/л /Cobalt Co, mg/L /	<0.01	<0.0054	15	Вор (B) м/л /Bor B, mg/L /	<2.4	<0.0032
6	Хар тугалга, Pb м/л Lead, Pb, mg/L /	<0.01	<0.0025	16	Галлий (Ga) м/л /Gallium Ga, mg/L /	-	<0.003
7	Цайр (Zn) м/л /Zinc Zn, mg/L /	<0.01	<0.0082	17	Стронци (Sr) м/л /Strontium Sr, mg/L /	<2.0	0.0061
8	Нийт хром (Cr) м/л /Chromium Cr, mg/L /	<0.05	<0.0057	18	Инди (In) м/л /Indium In, mg/L /	-	<0.0021
9	Нийт төмөр (Fe) м/л Iron, Fe, mg/L /	-	<0.0058	19	Таллий (Tl) м/л /Tallium Tl, mg/L /	-	<0.0008
10	Бисмут (Bi) м/л /Bismuth Bi, mg/L /	-	<0.0003	20	Ванадий (V) м/л /Vanadium V, mg/L /	-	<0.117

Шинжилгээ гүйцэтгэсэн /Test performed by/
Химич /Chemist/

Н. Халиунова /Khalunova N MSc/

Хянасан /Approved/

Лабораторийн эрхлэгч /Head of laboratory/

Д. Мөнхжүүл /Munkhjuul D MSc/

Хуудас/1

Энэ үйлчилгээний дүн нь тухайн дээжийн хувьд хүчинтэй. /The test result report is applicable to the sample/
Сорилтын лабораторийн зөвшөөрлийггүйгээр хуульчлалыг зөвшөөрнө. It is prohibited to reproduce the results without laboratory authorization/

Гал сэнтий ХХК

Хөрсний шинжилгээ



Чанар Хурд Давшил

ХАНЛАБ ХХК

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11 р хороо, Богд Жавзандамба
гуудамж 34/6 тоот, Хан Рацдан компанийн байр
Утас: 70109968, 99995316
<http://www.khanlab.mn>



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛГА №: 2023/1369-3

ЗАХИАЛАГЧИЙН НЭР:

БАЙГАЛЬ ОРЧНЫ СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ, Хөрс, 6
ТОО:

ДЭЭЖЛЭЛТ ХИЙСЭН ГАЗАР: Орхон аймаг, Баян-Өндөр сум, Гал Сэнтий ХХК

№	ЛАБОРАТОРИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ДУГААР	МОНИТОРИНГИЙН ЦЭГ	СОЛБИЦОЛ		Өндөршил, метр	ЭЛЕМЕНТ, %					ЭЛЕМЕНТ, мг/кг					
				Уртраг	Өргөрөг		Ca	Mg	Na	K	F _{сөмг}	As	Ba ^a	Be	Bi	Cd	
																	Уртраг
1	Л-16019	S-954	Хяналт	104°05'44.9"	49°01'39.2"	1266	2.66	0.68	2.31	1.78	3.24	19.46	621.9	<1.0	<10.0	<1.0	
2	Л-16020	S-955	Көмш	104°05'49.5"	49°01'20.8"	1296	1.17	1.02	1.93	1.92	3.36	17.68	611.0	<1.0	<10.0	<1.0	
3	Л-16021	S-956	Цэвэрэн 1 /гайбиг дотор/	104°05'46.3"	49°01'21.1"	1296	2.57	1.12	2.92	2.01	3.83	19.38	661.3	<1.0	<10.0	1.27	
4	Л-16022	S-957	Цэвэрэн 2 /хадан талбай/	104°05'43.7"	49°01'17.2"	1285	3.32	0.97	2.06	2.02	2.97	19.62	694.9	<1.0	<10.0	<1.0	
5	Л-16024	S-959	Аюулгүй хэсэг хангалт	104°05'46.0"	49°01'18.8"	1289	5.47	1.39	1.85	1.88	3.53	19.45	633.0	<1.0	<10.0	1.12	
6	Л-16025	S-960	Үйлдвэрийн урс хэсэг	104°05'49.0"	49°01'18.2"	1294	3.07	1.33	3.18	2.13	3.65	11.29	674.8	<1.0	<10.0	<1.0	
Атгестатчилсан Стандартчилсан Загвар																	
1	K-1306	Атгестатчилсан утга				2.40	0.94	2.61	1.19	2.61	1.01	473.0	0.91	0.05	0.06		
		Шинжилсэн утга				2.38	0.92	2.66	1.19	2.61	<5.0	466.4	<1.0	<10.0	<1.0		
MNS5850:2019													20.00	-	-	-	3.00

Хуудас 4-1

ИТГЭМЖЛЭГДСЭН

ЛАБОРАТОРИЙН

ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

TL 02

- 2023 оны 8 сард Байгаль орчны судалгаа шинжилгээний төвөөр ус, хөрсний шинжилгээг хийлгэсэн.
- Гадаргын усны шинжилгээг Далиу булгийн уснаас, гүний худгийн усны шинжилгээг Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ийн ИУ-н 3-р постны хажууд байрлах хяналтын цооноогоос авхуулсан.